Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэргээн засал, сургалт үйлдвэрлэлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төвийн даргын 2023 оны А/61 тоот ушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэргээн засал, сургалт үйлдвэрлэлийн төв нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 312,297.6 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 166,131.2 | 391,650.0 | 225,518.7 |
| Бараа материал | 609,879.9 | 562,670.1 | (47,209.7) |
| Үндсэн хөрөнгө | 6,047,476.5 | 5,556,869.9 | (490,606.5) |
| **Нийт хөрөнгө** | **6,823,487.6** | **6,511,190.0** | **(312,297.6)** |
| Өр төлбөр | 19,564.3 | 121,784.9 | 102,220.6 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 6,803,923.3 | 6,389,405.1 | (414,518.2) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **6,823,487.6** | **6,511,190.0** | **(312,297.6)** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс  авлага, бараа материал,үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн дансуудад материаллаг дүнгээр өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 391,650.0 мянган төгрөг болж 266,857.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нэмэлт санхүүжилтын авлага 7,105.7 мянган төгрөгөөр, ЭМДЕГ-аас авах авлага 384,520.5 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 23.8 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой.
- Урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 41,339.0 мянган төгрөгөөр буурсан нь "Файбер троника" ХХК-иас авах он дамжсан авлагыг барагдуулсантай холбоотой буурчээ.
- Бараа материал дансны үлдэгдэл 562,670.1 мянган төгрөг болж 47,208.9 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны зарцуулалтаар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас 92,576.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй авсан сургалтын бараа материалыг хүлээн авч, зарцуулсан.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,556,870.0 мянган төгрөг болж, 490,606.6 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 09-р сарын 25-ны өдрийн 455 дугаар тогтоолоор 103,294.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасч тайлант онд 765,123.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал хүлээн зөвшөөрч, төсвийн хөрөнгөөр 3,608.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,124.5 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 266,989.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй олгосон байна.

- Өр төлбөр дансны 121,784.9 мянган төгрөг нь үндсэн үйл ажиллагааны бэлэн бүтээгдэхүүний төлбөрийн урьдчилж орсон орлого 26,926.8 мянган төгрөг, эм, эмнэлгийн хэрэслийн төлбөрийн үлдэгдэл 45,809.7 мянган төгрөг, үйлдвэрийн тусгай зориулалтын материалын төлбөрийн үлдэгдэл 47,033.5 мянган төгрөг, шуудан холбоо, интернетийн 2,014.9 мянган төгрөгийн өглөг тус тус үүссэн.
- Засгийн газрын хувь оролцоо данс нь тайлант оны үр дүн 414,518.2 мянган төгрөгөөр буурч, Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6,389,405.1 мянган төгрөг болсон байна.

Тус байгууллагын программ хангамжийн дансанд бүртгэлтэй 2011, 2020, 2022, 2023 онуудад худалдан авч, ашиглаж байгаа 935.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программ, 580,000.0 мянган төгрөгийн өртөгтэй эмнэлгийн "Аксис" программ, 9,987.0 мянган төгрөгийн өртөгтэй үйлдвэрийн онлайн программ, 16,950.0 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн программ хангамжууд байна. Тайлант онд программ хангамж хөгжүүлэхтэй холбоотой зардал гараагүй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,575,506.8 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,427,119.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 130,000.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 15,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 5,147,626.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлуудыг 370,842.6 мянган төгрөгөөр бууруулж, 4,776,783.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 239,410.3 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,965,252.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,572,121.1 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,537,373.1 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээс улсын төсвөөс, 2,676,211.1, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,287,700.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 154,059.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 14,063.6 мянган төгрөг нийт 4,328,580.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал

үйл ажиллагааны зардалд 4,132,033.9 мянган төгрөгийг зарцуулсан. 196,546.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт гүйцэтгэлээр 4,132,033.9 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь цалингийн зардал 227,296.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,060.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,272.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 27,086.1 мянган төгрөг, хангамжийн бараа материал 9,944.0 мянган төгрөг, Норматив зардал 135,025.7 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 255.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 3,398.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Урсгал үйл ажиллагаанд 4,132,033.9 мянган төгрөгийг зарцуулж өмнөх оны төлбөртэй үйлчилгээний авлагаас 121,220.0 мянган төгрөг зарцуулагдсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 72206-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил хам хамгаалал | 4,537,373.1 | 4,132,033.9 | 405,339.2 | 91.1 |
| **ДҮН** | | **4,537,373.1** | **4,132,033.9** | **405,339.2** | **91.1** |
| 1 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 3,405,218.6 | 3,293,326.7 | 111,891.9 | 96.7 |
| 2 | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал | 1,024,047.5 | 730,600.2 | 293,447.3 | 71.3 |
| 3 | 80219-Харуул хамгаалалтын зардал | 64,984.1 | 64,951.6 | 32.5 | 99.9 |
| 4 | 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 43,125.9 | 43,125.9 | 00 | 100.0 |
| **НИЙТ** | | **4,537,373.1** | **4,132,033.9** | **405,339.2** | **91.1** |

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулсан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 91.1 хувийн биелэлтэй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл"-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.Үүнд:

1. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаалаар 79 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 77 орон тоогоор ажилласан байна. Тус байгууллага нь тайлант онд гадаад харилцааны ажилтан нярайн асрах чөлөөтэй, 1 хөдөлгөөн засалчийн ажлын байрны зарын дагуу ажилтан ирээгүй тул нэмж хүн ажиллуулаагүй байна.

2. Даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 дугаар тушаалаар хоолны зардлыг 25.0 мянган төгрөгөөр тогтоож, тайланд онд 367,008.9 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон.
3. Гадаад албан томилолтоор ажиллаагүй, сургалтын зардал, хэвлэл мэдээлэл болон төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардлууд гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтын дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 15,613.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 8,507.9 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 7,105.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь 2025 онд 9 нэр төрлийн төсөл арга хэмжээ санхүүжүүлэхээр 804,451.9 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталсан ба 7 байгуулагатай 781,239.4 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, худалдан авах ажиллаагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэргээн засах, сургалт үйлдвэрлэлийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Сэргээн засах, сургалт үйлдвэрлэлийн төв, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Пийк ОМ Аудит” ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Болортуяа, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Сэргээн засах, сургалт үйлдвэрлэлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 5,639,463.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 56,394.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд Төрийн хэмнэлтийн хуулийг баримталж ажилласан, хориглосон болон хязгаарласан гүйлгээг санхүүжүүлээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайланд хугацаанд 171 мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар илэрсэн 5,558,110.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 41,475.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 2 | 41,475.4 | 2 | 41,475.4 | 100.0 |
| **Нийт дүн** | **2** | **41,475.4** | **2** | **41,475.4** | **100.0** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудалд анхаарлаа хандуулж аудитын горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв, тодруулгуудын хамт бэлтгэж байгаа эсэх;
- Хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй асуудалд горим сорил хэрэгжүүлэх

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 117,448.6 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснээс аудитын явцад 117,448.6 мянган төгрөгийн 2 алдааг залруууллаа.

*Залруулсан алдаа:*

- Хэвтэн эмчлүүлэгчийн ор хоногийн төлбөрийн орлогыг мөнгөн сууриар бүртгэснээс тайлант оны 2,234.1 мянган төгрөгийн орлого болон авлагыг дутуу бүртгэсэн;
- Юнивишн ХХК-ийн тооцооны 2,014.9 өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй;
- Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн дүнгээс цахим хасалтаар буурсан 113,199.6 мянган төгрөгийг санхүүжилтийн дүнг санхүүгийн тайланд тусгаагүй;

Эдгээр алдаанууд нь  Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалттай нийцээгүй, УСННБОУС-24 Санхүүгийн тайлан дахь Төсвийн мэдээллийн тодруулга болон “Нийцсэн бөгөөд зохистой”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 81,888.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэнд, 2,030.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 32,450.6 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 47,408.3 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 81,888.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 25,494.4 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Тус төвийн захирал нь эрх бүхий албан тушаалтны тушаал, шийдвэргүйгээр төвийн захирлын 2025 оны А/27, А/35, А/49 дүгээр тушаалуудаар өөртөө нийт 2,030.0 мянган төгрөгийн орон нутагт ажилласан гэх үндэслэлээр илүү цагийн хөлс авсан.

Энэ нь Төрийн, албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-т “Төрийн албан хаагчид дараах нөхөх төлбөрийг олгоно”, 59.1.1-т “Албан томилолтын зардлыг”, 59.2-т “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам, түүний хэмжээг Засгийн газар тогтооно”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 12 дугаар зүйлийн 12.1-т “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв нь хууль зөрчиж эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон илүү цагийн хөлснийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д “Мэргэжлийн боловсролын сургууль, коллежийн багшид таван жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгох” гэсэн заалтыг үндэслэн 3 багшид мөнгөн тэтгэмж олгосон төвийн захирлын 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/51 дугаартай тушаалд 6 сар гэж буруу тусгаснаас нийт 17,450.6 мянган төгрөгийн зөрүү гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.6.1-т “Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Архив, албан бичиг хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т “Байгууллагын зохион байгуулалтын нэгж /газар, хэлтэс/-ийн дарга албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, журам, стандартыг өөрийн хариуцсан нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, цаасан болон цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй, ашиглах боломжтой байхад хяналт тавина.” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал, шийдвэрийн эхийг алдаатай бэлдсэн, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2.Тус төвийн захирлын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн “Нэмэгдэл хөлс олгох тухай” А/34 дугаартай тушаалаар "Хөдөлмөр хамгааллын салбарын ажилтны өдөр"-ийг тохиолдуулан ажилтнуудад батлагдсан төсөвт тусгагдаагүй 15,000.0 мянган төгрөгийн нэмэгдэл хөлсийг хавтгайруулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй

байхаар төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Батлагдсан төсөвт тусгагдаагүй нэмэгдэл хөлс олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Бараа материалтай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Бараа материалын эргэлтийг оновчтой төлөвлөөгүй, дуусах хугацаанд хяналт хэрэгжүүлээгүйн улмаас 5 төрлийн 14 ширхэг, 2,750.0 мянган төгрөгийн лабораторийн уусмал урвалж материалуудын хадгалах хугацаа дуусч, ашиглах боломжгүй болсон байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"

*Өгсөн зөвлөмж*: Эм, эмнэлгийн хэрэгслийн эргэлтэнд хяналт тавьж, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

**2. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Тайлант онд “Файбер троника” ХХК-иас авах авлагыг 41,339.0 мянган төгрөгийн протезийн түүхий эдээр барагдуулан тооцоо хаасныг цахим төлбөрийн и-баримтаар баталгаажуулаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"

*Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэл, тайлагналыг холбогдох журам, зааврын дагуу анхан шатны баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг бүртгэлд тусгах.

**3. Бараа материалын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Аудитын явцад хийсэн хяналтын тооллогоор эмийн агуулахаас 17 нэр төрлийн 413 ширхэг 1,304.4 мянган төгрөгийн эмийн материал зөрүүтэй байна. Мөн түүхий эд материалын агуулах эмх цэцгүй хөрөнгийн нэр, маркыг бичиж хаягжуулаагүй байгаагаас хяналт тавих боломжгүй, хөрөнгө дутагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-д "Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил, гүйлгээг заавал тусгана", 14.4.6-д "Нягтлан бодох бүртгэлд бүх зардал-ыг заавал бүртгэнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой” байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Агуулах болон хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, тооллогыг үнэн зөв явуулж, үр дүнг цаг тухайд нь бүртгэлд тусгаж байх.

**4. Өглөгтэй холбоотой асуудал**

<u>*Илрүүлэлт:*</u> Тайлант онд 2,014.9 мянган төгрөгийн тооцооны өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 5 дугаар зүйлийн 5.1.5 "Хариуцлагатай байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u> Өглөгөө барагдуулах, төсвийг зохистой удирдаж, өглөг үүсгэхгүй ажиллах

**5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

<u>*Илрүүлэлт:*</u> Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 3,054,251.5 мянган төгрөгийн анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй, 873 ширхэг үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1 “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцээгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u> Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгүүдийг ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох эсэхийг холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хэвтэн эмчлүүлэгчийн ор хоногийн төлбөрийн орлогыг мөнгөн сууриар бүртгэснээс тайлант оны 2,234.1 мянган төгрөгийн орлого болон авлагыг дутуу бүртгэсэн байна | 1 | 2,234.1 | | | 1 | 2,234.1 | 1 | 2,234.1 | | | | |
| 2 | Юнивишн ХХК-ийн тооцооны 2,014.9 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна. | 1 | 2,014.9 | | | 1 | 2,014.9 | 1 | 2,014.9 | | | | |
| 3 | Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн дүнгээс цахим хасалтаар буурсан 113,199.6 мянган төгрөгийг санхүүжилтийн дүнг санхүүгийн тайланд тусгаагүй байна. | 1 | 113,199.6 | | | 1 | 113,199.6 | 1 | 113,199.6 | | | | |
| | **Дүн** | **3** | **117,448.6** | | | **3** | **117,448.6** | **3** | **117,448.6** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалт ны тоо | Тоо | Дүн |
| 1 | Тус төвийн захирал нь эрх бүхий албан тушаалтны тушаал, шийдвэргүйгээр төвийн захирлын 2025 оны А/27, А/35, А/49 дүгээр тушаалуудаар өөртөө нийт 2,030.0 мянган төгрөгийн орон нутагт ажилласан гэх үндэслэлээр илүү цагийн хөлс авсан. | 1 | 2,030.0 | 1 | 2,030.0 | | | | | | | | |
| 2 | Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д “Мэргэжлийн боловсролын сургууль, коллежийн багшид таван жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгох” гэсэн заалтыг үндэслэн 3 багшид мөнгөн тэтгэмж олгосон төвийн захирлын 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/51 дугаартай тушаалд 6 сар гэж буруу тусгаснаас нийт 17,450.6 мянган төгрөгийн зөрүү гарсан байна. | 1 | 17,450.6 | | | 1 | 17,450.6 | | | | | | |
| 3 | Тус төвийн захирлын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн “Нэмэгдэл хөлс олгох тухай” А/34 дугаартай тушаалаар "Хөдөлмөр хамгааллын салбарын ажилтны өдөр"-ийг тохиолдуулан ажилтнуудад батлагдсан төсөвт тусгагдаагүй 15,000.0 мянган төгрөгийн нэмэгдэл хөлсийг хавтгайруулан олгосон. | 1 | 15,000.0 | | | 1 | 15,000.0 | | | | | | |
| 4 | Бараа материалын эргэлтийг оновчтой төлөвлөөгүй, дуусах хугацаанд хяналт | 1 | 2,750.0 | | | | | 1 | 2,750.0 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлээгүйн улмаас 5 төрлийн 14 ширхэг, 2,750.0 мянган төгрөгийн лабораторийн уусмал урвалж материалуудын хадгалах хугацаа дуусч, ашиглах боломжгүй болсон байна. | | | | | | | | | | | | |
| 5 | Тайлант онд Файбер троника ХХК-иас авах авлагыг 41,339.0 мянган төгрөгийн протезийн түүхий эдээр барагдуулан тооцоо хаасныг цахим төлбөрийн ибаримтаар баталгаажуулаагүй байна. | 1 | 41,339.0 | | | | | 1 | 41,339.0 | | | | |
| 6 | Аудитын явцад хийсэн хяналтын тооллогоор эмийн агуулахаас 17 нэр төрлийн 413 ширхэг 1,304.4 мянган төгрөгийн эмийн материал зөрүүтэй байна. Мөн түүхий эд материалын агуулах эмх цэцгүй хөрөнгийн нэр, маркыг бичиж хаягжуулаагүй байгаагаас хяналт тавих боломжгүй, хөрөнгө дутагдах эрсдэлтэй байна. | 1 | 1,304.4 | | | | | 1 | 1,304.4 | | | | |
| 7 | Тайлант онд 2,014.9 мянган төгрөгийн тооцооны өглөг үүсгэсэн байна. | 1 | 2,014.9 | | | | | 1 | 2,014.9 | | | | |
| 8 | Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 3,054,251.5 мянган төгрөгийн анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй, 873 ширхэг үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | | **8** | **81,888.9** | **1** | **2,030.0** | **2** | **32,450.0** | **5** | **47,408.3** | **-** | **-** | **-** | **-** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 61/A0150169 Улаанбаатар хот

САГ-2026/205/НА-СТА-ТШ3

Төлбөрийн акт тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн захирал нь эрх бүхий албан тушаалтны тушаал, шийдвэргүйгээр төвийн захирлын 2025 оны А/27, А/35, А/49 дүгээр тушаалуудаар өөртөө нийт 2,030,000.00 (Хоёр сая гучин мянган) төгрөгийн орон нутагт ажилласан гэх үндэслэлээр илүү цагийн хөлс авсан.

Энэ нь Төрийн, албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-т "Төрийн албан хаагчид дараах нөхөх төлбөрийг олгоно", 59.1.1-т "Албан томилолтын зардлыг", 59.2-т "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам, түүний хэмжээг Засгийн газар тогтооно", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 12 дугаар зүйлийн 12.1-т "Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн"-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв нь хууль зөрчиж эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон илүү цагийн хөлсний 2,030,000.00 (Хоёр сая гучин мянган) төгрөгийг захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтмаагаар нөхөн төлүүлж, Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн нягтлан бодогч /Ж.Буянхүү/-д даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН<br>ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ<br>АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР<br>ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР А.МӨНХЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 313/А0150169 Улаанбаатар хот

САГ-2026/205/НА-СТА-ТШ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн захирлын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Нэмэгдэл хөлс олгох тухай” А/34 дугаартай тушаалаар "Хөдөлмөр хамгааллын салбарын ажилтны өдөр"-ийг тохиолдуулан ажилтнуудад батлагдсан төсөвт тусгагдаагүй 15,000,000.00 (Арван таван сая) төгрөгийн нэмэгдэл хөлсийг хавтгайруулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсөвт тусгагдаагүй нэмэгдэл хөлс олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Алтмаа/, нягтлан бодогч /Ж.Буянхүү/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР А.МӨНХЦЭЦЭГ

9006109
АТА16087
902/061411

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 312/А0150169 Улаанбаатар хот

САГ-2026/205/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д “Мэргэжлийн боловсролын сургууль, коллежийн багшид таван жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгох” гэсэн заалтыг үндэслэн 3 багшид мөнгөн тэтгэмж олгосон төвийн захирлын 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/51 дугаартай тушаалд 6 сар гэж буруу тусгаснаас нийт 17,450,550.00 /Арван долоон сая дөрвөн зуун тавин мянга таван зуун тавин/ төгрөгөөр зөрүү гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.6.1-т “Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Архив, албан бичиг хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т “Байгууллагын зохион байгуулалтын нэгж /газар, хэлтэс/-ийн дарга албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, журам, стандартыг өөрийн хариуцсан нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, цаасан болон цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй, ашиглах боломжтой байхад хяналт тавина.” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1 “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тушаал, шийдвэрийн эхийг алдаатай бэлтгэсэн, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Алтмаа/, нягтлан бодогч /Ж.Буянхүү/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР А.МӨНХЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*